



МОНГОЛЫН АЙМГИЙН
ТӨВ НОМЫН САН

АНГЛИ ХЭЛ СУРЦГААЯ

/Бүртгэн мэдээлэх нэмэлт/



2021 он

ӨМНӨХ ҮГ




Англи хэл нь Англид үүссэн, баруун Германы хэл юм. Энэ нь дэлхийн хамгийн түгээмэл хэлний нэг бөгөөд Нэгдсэн Вант Улс, АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланд, Ирланд, Карибын орнуудад албан ёсны хэл болдог. Англи хэлээр дэлхий дээр 310 сая хүн төрөлх хэлний хувиар, мөн тооны хүн хоёрдогч хэлний хувиар ярьж байна.

Англи хэл нь өнөө үед бусад хэлтэй харьцуулахад маш олон салбарт өргөн хүрээнд хэрэглэгддэг бөгөөд бизнес, технологи, шинжлэх ухаан, боловсролын аль ч салбарт ашиглагддаг гэдгээрээ давуу талтай. Та олон гадаад хэл дундаас Англи хэлийг сонгон сурахаар шийдсэн бол Англи хэл анхлан суралцагчдад зориулсан дараах номуудыг сонгон судлаарай.

1. Алтангэрэл Д.

Англи хэл сурах бичиг= English.- УБ., 1997.-
143х.

Энэхүү номоос та богино хугацаанд чөлөөтэй уншдаг, ойлгодог, орчуулдаг, хэдэн арван сэдвээр ярвдаг төдийгүй Таны мэдлэгийн хүрээ тэлж, өөртөө шинэ ертөнц нээж амьдрал тань баяр баяслаар дүүрч, шинэ ертөнцөд хөл тавьсан мэт мэдрэмжийг авах болно. Та энэ сурах бичгийг тогтож үзвээс цаашид англи хэлийг төгс эзэмших суурьтай болох болно.



2. Англиар алдаагүй асууж, хариулцгаая / Хян. Б.Энэбиш .- Улаанбаатар, 2008.- 92х.- ISBN 978-99929-8-157-3



Манайд англи хэлний сурах бичиг, толь голлосон нилээд ном хэвлэгдэн гардаг хэдий ч англи хэлээр ярих, түүний дотор асуулт тавих, хариулахтай холбоотой олон сэдвийг хамарсан ном, товхимол хараахан гараагүй байна. Тиймээс ОХУ-ын эрдэмтэн В.В.Голованёвын бичсэн

"Англиар алдаагүй асууж, хариулцгаая" номыг

орчуулан та бүхэнд хүргэж байна. Номонд нийт 70 хичээл орсон бөгөөд тэдгээр нь танд англиар асуултыг зөв тавьж, зөв хариулахад тус болно.

3. Арго Б.

Англи хэл өөрөө сурах бичиг буюу хэл сурах хялбар аргууд-1 / Хян. Г.Одгэрэл, Г.Оюунбилэг.- Улаанбаатар, 2005.- 181х.- ISBN 99929-6-202-Х.

Бидний гол зорилго юу вэ? Би та нарыг хоёрхон долоо хоногийн дотор англи хэлээр яриулж сургах ба дүрмийн системтэй бүрэн мэдлэг олгох ёстой. Та нар мөн энэ хугацаанд ярьж сурах ба дүрмийн мэдлэгтэй болох ёстой. Англи хэл сурахад сэтгэлгээ, сэтгэл хоёрыг арга билиг хоёр шиг хослуулна шүү.



4. Арго Б.

Англи хэл өөрөө сурах бичиг буюу хэл сурах хялбар аргууд-2 / Хян. Г.Одгэрэл, Г.Оюунбилэг.- Улаанбаатар, 2005.- 171х.- ISBN 99929-6-202-Х.

Хэлийг сурах доори 2 төрлийн үндсэн дараалал байдаг.

1-рт: Эхлээд ярьж сураад, дараа нь дүрмийг нь үзэж ойлгох,

2-рт: Эхлээд дүрмийг нь судалж ойлгоод дараа нь харж сурах. Гэтэл хоцрогдсон сургалтанд яриа дүрэм 2-ыг шууд холиод эмх замбараагүй үздэгээс болж хүмүүс хэлийг сурч чаддаггүй. Зүйрлэж хэлэх юм бол муу мах гурилыг хррорнд нь хольж буцалгаад амтлагчаар амтлаад хүнд өгнө гэсэн үг.



5. Арго Б.

Англи хэл өөрөө сурах бичиг буюу хэл сурах хялбар аргууд-3 / Хян. Г.Одгэрэл, Г.Оюунбилэг.- 2006.- 313х.: ISBN 99929-6-202-Х.



Англи хэлний ярианы дадлага буюу үгийг хэлбэр болон агуулгын талаас эргүүлэх, нэр ба үйл үгийг эргүүлэх, дүрмийн болон дүрмийн бус үйл үг, үйл үгийг 20 цагаар эргүүлэх, орчуулгын онол.

6. Аялал жуулчлал, зочид буудлын ажилтны англи хэл= English for managers of tourism and hotel business / Хян Б.Энэбиш: Мөнх дардас, Улаанбаатар.- 2009.- 159х.- ISBN 978-99929-8-140-7.

Дэлхийд нэн эрчимтэй хөгжиж буй аялал жуулчлал нь манайд улсад ч мөн түргэн хөгжиж улс орны эдийн засагт чухал нөлөө үзүүлж байгаа билээ. Энэ цаг үед аялал жуулчлал, зочид буудлын үйл ажиллагаатай сурах бичиг хараахан гараагүй учраас бид тус номыг гаргалаа.



Сурах бичиг нь тус бүр 9 хичээлтэй, 2 үндсэн хэсгээс бүрдэнэ. Хичээл бүр нь тодорхой тексттэй, гол, өгүүлбэрийн орчуулга, дасгал, унших нэмэгдэл сэдэв материалтай болно.

7. Бат-Ирээдүй Ж., Номунзул Б.

Монгол-Англи хэлц үг, хэвшмэл хэллэгийн дүймэн / Хян. Х.Дэлгэрмаа, Б.Хонгорзул.- Улаанбаатар: ADMON ХХК, 2007.- 178х.- ISBN 978-99929-0-212-4.



Аливаа хэлний хэлц үг бол тэр хэлний ЭРДЭНЭСИЙН САН гэж профессор М.Базаррагчаа нэгэнтээ бичжээ. Монгол Англи хэлний хэлц үгийг анзаарч байхад хоорондоо тун адилхан бүтэцтэй, ижил утгатай хэлц үг цөөнгүй байна. Тухайлбал, тонгол хэлний цусан төрөл= blood brother, торны цаана=behind bars, нүд ирмэх зуур= in a flash, алт шиг хүн= as good as gold,

ясан толгой=bone headed үэрэг хэлц нь бүтцээрээ төдийгүй утгаараа ямар ч зөрөөгүй таарч байгаа юм.

8. Батсүх Г.

Англи хэл эхлэн сурах бичиг= English for beginners.- Улаанбаатар, 1992.- 164х.

Уг сурах бичиг 28 хичээлээс бүрдэнэ. Хичээл тус бүр нь авиа болон хэлний зүйн дүрэм тайлбарласан онолын материал, тэднийг баяжуулсан жишээ дасгалтай юм. Гадаад хэл сурахад уг хэлний аялага, дуудлагыг зөв эзэмших асуудал туйлын чухал ач холбогдолтой учир англи хэлний авиануудыг дуудахад өгүүлэх эрхтэний гүйцэтгэх ажиллагааг зураг дээр нэг бүрчлэн тайлбарлаж, авиа тус бүрийн галигийг үзүүлэхийг зорьсон.



9. Баярмөнх Ц.

IBT TKFEL-ийн шалгалтанд хэрхэн амжилттай бэлтгэх вэ?.- Улаанбаатар: MN технологи ХХК., 2007.- 495х.

Энэхүү номыг ETS буюу боловсролын тестийн байгууллагаас тусгайлан



боловсруулсан бөгөөд өөрөөр хэлбэл жинхэнэ шалгалтын тестийг боловсруулагсдаас зохиосон сурах бичиг юм. IBT TOFEL-нийн шөлгөлтөнд бэлтгэхэд хэрэгтэй бүхэн энэ сурах бичигт байгаа учраас өндөр хөгжилтэй орны их сургууль, коллежид элсэн ороход тань туслах болно.

10. Болдбаатар Д.

Гадаад хэлийг төгс сурахуйн нууц / Хян. С.Туяагэрэл.- Улаанбаатар: Бэмби сан, 2005.- 64х.




Гадаад хэлийг амжилттай сурна гэдэг сургалтын орчин, сайн сурах бичиг, багшлах боловсон хүчний нөөц зэрэг олон хүчин зүйлсээс шалтгаалдаг нарийн төвөгтэй үйл явц юм. Тэр тусмаа хувь хүний хүчин уйгагүй хүчин чармайлт шийдвэрлэх үүрэгтэй. Гадаад хэлийг сурахад тохиолддог сэтгэлзүйн бэрхшээлийг гэтлэн давахад энэ ном тодорхой хэмжээгээр иус дөхөм болох нь дамжиггүй.


11. Бонк Н.А.

Англи хэлийг алхам алхамаар: 2 цувр.-
Улаанбаатар: Соёмбо принтинг, 2005.- 380х.

Тус сурах бичиг нь “Англи хэлийг алхам алхамаар” хэмээх иж бүрдлийн дэд хэсэг. Энэ бүтээл эхний хэсгийнхээ хамтаар англи хэлний бүх үндсэн бүтцүүдийг хамран тайлахын сацуу үгсийн нөөц, тэдгээрийн хэрэглэгдэх хүрээг үлэмж хэмжээгээр өргөжүүлсэн. Харилцан яриа, текст нь орчин үеийн амьдралд нэн түгээмэл олон сэдвүүдийг хамарсан ба бие даан англи хэл суралцагчдад нэн тохиромжтой.



12. Бонк Н.А. ба бус



Англи хэлийг алхам алхамаар
цогц сурах бичиг: 1цувр /
Н.А.Бонк, И.И.Левина,
И.А.Бонк.: Ред. М.Тэгшжаргал.-
Улаанбаатар: Мөнхийн үсэг
ХХК., 2012.- 585х.

Тус сурах бичиг / иж бүрдлийн
1-р хэсэг/ нь англи хэлийг сурах
нэн дэвшилтэт аргачлал,

шинэлэг зарчимд тулгуурласан болно. Авиан зүй, зөв бичихүйн дүрмүүдийг онцын хүндрэл бэрхшээлгүйгээр эзэмших дадлыг суулгаж, шинэ үг хэллэг, өгүүлбэр, хэл зүйнбүтцийг тухай бүрт нь ой ухаанд хоногшуулах бөгөөд, сургалтын өндөр шаардлыг хангана.

13. Бонк Н.А.

Англи хэлийг алхам алхамаар цогц сурах бичиг: 2 цувр / Ред. Т.Тэгшжаргал Т.- Улаанбаатар: Бит Пресс ХХК., 2012.- 415х.

Тус сурах бичиг нь “Англи хэлийг алхам алхамаар” хэмээх иж бүрдлийн дэд хэсэг юм. Эл бүтээл эхний хэсгийнхээ хамтаар англи хэлний бүх үндсэн бүтцүүдийг хамтран хамран тайлахбн сацуу үгсийн нөөц, тэдгээрийн хэрэглэгдэх хүрээг үлэмж хэмжээгээр өргөжүүлсэн буй.



14. Гүн-Үйлс Д.

Англи монгол зэрэгцүүлсэн хэл зүй.- Улаанбаатар: 2007.- 413х.- ISBN 978-99929-1-239-1.

Энэхүү ном нь англи хэл зүйн, өөрөөр хэлбэл англи хэлний үг зүй, өгүүлбэр зүйн холбогдол бүхүй бүх




дүрэм, тайлбар сэлтийг өөртөө багтааснаас гадна монгол хэл зүйн сэдэв зохирох зүйлүүдийг тухайлан ангилсан судалгаа болоод нийтийн хэрэглээнд зориулсан бүтээл юм. Хэл зүйн дүрэм, тайлбар тус бүрт оногдох, хавсарга орчуулга бүхүй 3000 гаруй жишээ энгийн

амьдралын хийгээд хүмүүн хоорондын харилцааны өргөн хүрээг хамарсан буй. Англи хэлийг бие даан суралцагчид болон англи хэлний чиглэлийн багш, оюутан сурагчид үзэж ашиглах бүрэн боломжтой.

15. Гүн-Үйлс Д.

Англи хэлний нууц товчоо.- Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК., 2006.- 238х.- ISBN 978-99929-829-0-Х.

Англи хэл үзэж буй Монголчуудын гаргадаг нийтлэг алдаа, тохиолдож болох хүндрэлүүд, ойлгомжтой үг хэллэгүүдийг товч тодорхой тайлбарласны сацуу, авиа зүй, өгүүлбэр зүйн талаас нь энгийнээр ойлгуулахыг зорьсон тус бүтээлийг мэргэжилтнүүдийн дуу хоолой бүхий аудио CD дагалдана.



16. Гүн-Үйлс Д., Нарангэрэл Ц.


Англи хэлний өгүүлбэр зүй= English Syntax.-
Улаанбаатар: Мөнхийн үсэг ХХК., 2007.- 217х.-
ISBN 978-99929-1-205-7.

Англи хэлний зүйн томоохон салбар болох Өгүүлбэр Зүйн бүрэн хэмжээний энэхүү ном нь тухайн салбарт холбогдох буюу дүрэм, тайлбар, жишээнүүдээс гадна түлхүүр хариулт бүхий дагалдах дасгалуудыг өөртөө багтаасан болно. Англи хэлийг бие даан суралцагчид хийгээд их дээд болог англи хэлний чиглэлийн сургуулийн багш, оюутнууд үзэж ашиглах бүрэн боломжтой.



17. Гэндэндарам Ж.

English Grammar=Anthology of mongolian poetry.- Улаанбаатар: 2017.- 324х.



Монголын нэртэй зохиолчдын бүтээлүүдийг Англи хэл дээр орчуулан нийтэлсэн болно. Англи Монгол хэллэгийг тулган үзэхэд хэрэгтэй. Зуун найман эрдэнэсийн эрх зохиолын товч агуулга: Ардын уран зохиолч Ш.Сүрэнжав

тус бүтээлээ танилдаа явуулахад "Ямар гайхамшигтай бүтээл вэ? дахин хэвлээд нилээн хэдэн хувийг явуулаа би найз нөхөддөө өгье" гэснээр Ш.Сүрэнжав үүнийгээ дахин хэвлүүлж байлаа.


18. Даваа Д.

Англи-Монгол түгээмэл 1000 үгийн толь.-
Улаанбаатар: Шинжлэх ухааны Эрдэм пүүсийн
үйлдвэр, 1991.- 32х.

Олон салаа утгатай үгийг орчуулахдаа орчин үед хамгийн өргөн хэрэглэгддэг нэг буюу хэд хэдэн утгыг гаргахыг зорилоо. Үйл үгийн ар талд түүний хоёр хэлбэрийг хаалтанд оруулж бичсэн.



19. Даваахүү П.



let's speak English!.-
Улаанбаатар: Мөнхийн үсэг
ХХК., 2008.- 108х.- ISBN 978-
99929-1-226.

Тус номонд бидний амьдралын адар тутам тохиолдох энгийн үг хэллэгээс эхлээд сонирхолтой өгүүллэг, харилцан яриа, америк хар яриа, шилдэг эссе

гэх мэт өргөн хүрээтэй судлагдахуунуудыг Англи, Монгол хоёр хэл дээр зэрэгцүүлэн орчуулсан буй.


20. Дашдондов Ц.

Англи хэлний хураангуй үгийн толь.-
Улаанбаатар: 1983.- 135х.

Энэ баяхан толийг хэвлэл мэдээллийн ажилтан, орчуулагчид, оюутан сурагч хийгээд гадаад хэл сонирхогч хэн хүний хэрэгцээнд дүйлгэхийг бодолцсон. Толийн төгсгөлд Монгол зарим нэр томъёог Англиар орчуулсан хавсралт бий. Мөн манай улсын гадаад харилцаа өргөнтэй зарим байгууллагын нэрийг англиар яаж хураангуйлдгийг үзүүлэн тайлбар хийсэн.



21. Дорждэрэм Л.



Англи хэлний анхан шатны сонсох дадал-1.- Улаанбаатар: 2010.- 102х.- ISBN 99929-3-142-6.

Англи хэлээр зөв уншиж, сонсож, ойлгож, орчуулж сурах CD-тэй сурах бичиг.

22. Драгункин А.Н.

Англи хэлийг гурван бүтэн нэг хагас өдөрт.-
Улаанбаатар.: ADMON ХХК.- 2008.- 230х.- ISBN
978-99929-0-507-7.

23. Драгункин А.Н.

Англи хэлийг гурван бүтэн нэг хагас өдөрт.-
Улаанбаатар: 2002.- 130х.- ISBN: 978-99929-0-
507.

Хэрэв та Англи хэлийг ямар нэг хэмжээгээр үзэж байгаад шантарч замын хагаст орхисон юм уу эсвэл сургалтын уламжлалт аргаар хичээллээд хүссэн үр дүнд хүрч чадаагүй бол энэхүү ном танд зориулагдсан. Харин та англи хэлийг эхлэн үзэж байгаа бол тус номын сонгон суралцах хэсгийг юцны түрүүнд судлаарай. Энэхүү номыг авчмагцаа та зорилго чиглэлтэйгээр биеэ дайчлан ажиллавал 3,5 өдрийн дараа англиар зөв ярьж эхлэх болно.



24. Лувсанжав Ч.

Англи хэл өөрөө сурах бичиг / Хян.
М.Шинэхүү, Т.Дулмаа.- Улаанбаатар: Улсын
хэвлэлийн газар, 1969.- 302х.

Англи хэлний өгүүлбэрийн доторуг найруулах ёс нь бусад Европ хэл адил, Монгол хэлний үг найруулгаам гол төлөв тонгоруу байдаг. Монгол хэлний үг холбон найруулахдаа нөгөө үгийнхээ утгыг тодруулан үзүүлэгч үг нь тодруулгаж байгаа үгийнхээ өмнө ордог гэх мэт Англи хэлний дүрэм, цаг, шинэ үг, тайлбар, дасгал зэрэг анхлан сурагчдад зориулсан маш дэлгэрэнгүй бөгөөд ойлгомжтойгоор энэхүү номд бичсэн.



25. Лхагвасүрэн Б., Patrick Thompson.

Англи хэл 100 өдөрт сонсох арга барилаар эрчимтэй сурах / Хян. Б.Мөнгөнтуяа.- Улаанбаатар: Соёмбо принтинг, 2018.- 240х.- ISBN 978-99962-75-83-8.



Богино хугацаанд хэл сурах шалгарсан арга болох сонсох замаар харьцуулан хэл сурч буй хүнийг албадан залхаах биш, хүүхэд яаж хэлд ордог тэр ёсоор хүсэл сонирхлыг төрүүлж, уяг үргэлж гэртээ, гадаа, тээврийн хэрэгслээр зорчихдоо, ер нь хаа ч, хэзээ ч сонсон суралцаж болох гайхамшигт

боломжийг олгож байна.

26. Мөнхтэгш Р.

Одоо англи үг цээжлэхгүй байхыг чинь харна аа.- Улаанбаатар: 2018.- 464х.- ISBN 978-99978-2-586-5.

Энэхүү номыг англи хэл шимтэн суралцагч бүх хүмүүст зориулж байна. толь бичгийг хуудасных нь тоотой цээжилдэггүй юмаа гэхэд өдөрт багадаа 300 англи үгс цээжлэх бүрэн боломжтой гэдгийг уг ном илтгэн харуулна.



27. Нарантуяа Ж.

Англиар эссэ бичихэд суралцах нь / Хян П.Увш.- Улаанбаатар: 2015.- 113х.



Англиар хэл зүйн хувьд алдаагүй бичиж, утгын хувьд эх хэлээр яригсдад ойлгогдохуйц, оновчтой бичиж сурах амаргүй. Уг гарын авлагыг англиар бичих үйл явцыг хялбаршуулан тайлбарлаж, холбогдох үндсэн ойлголт, нэр томъёог америкийн бичгийн хэл судлаач нарын бүтээлд баримталсан онолын

үндэслэлд тулгуурлан урт, богино эссэ бичиж сурах, англи академик бичвэрийн анхны ойлголт өгөх зорилгоор боловсруулсан байна. Мөн iBT

TOEFL шинээр нэвтэрч байгаа энэ цаг үед бичгийн хоёр төрлийн даалгавартай тус шалгалтанд бэлдэж байгаа хүмүүст нэн шаардлагатай гарын авлага юм.

28. Нарантуяа Ж.

Тоефлд бэлтгэх дүрмийн дасгалын ном=Тоeфl Grammar workbook / Хян. Л.Манга, Л.Итгэл.- Улаанбаатар: 2012.- 182х.


Англи хэлний зүйн нэр томъёо, ойлголтуудын тайлбартай энэхүү дасгалын номыг англи хэл сурч буй аль ч түвшний хүн хэрэглэж болно. Монгол улсад англи хэлний зүйг үзэж судлахдаа төрөлх хэлээ судалж буй англи эрдэмтдийн үзэл бодлоос нилээд зөрүүтэй авч үзсэн.



29. Номинзул Т., Ундармаа Н.

Англи хэл өөрөө сурах бичиг= Self study English / Хян. Н.Шүрхүү, Т.Тогтохтөр.- Улаанбаатар: Соёмбо принтинг, 2015.- 542х.- ISBN 978-99962-2-711-0.

Номын эхний хэсэг болох "Phonetics and Pronunciation section"-д англи хэлийг унших авиа зүйн дүрмийг багтаасан англи хэлний авиа зүйн 101 дүрэм жишээний хамт, 2-р хэсэгт англи хэлний




1001 дүрмийг ойлгосноо шалгах 4001 дасгалын хамт, сүүлчийн 3-р хэсэгт англи хэлний үгсийн сангаа нэмэгдүүлэх 4001 шинэ үгсийг 40 сэдвийн хүрээнд англи тайлбар болон монгол орчуулгатай нь мөн сурсан шинэ үгүүдээ шалгах олон төрлийн дасгал ажлын хамт оруулж өгчээ. Энэ номонд

багтсан дасгал ажил, унших материалууд зэрэг нь суралцагчдын үгсийн санг нэмэгдүүлж, ярих чадварыг түлхүү хөгжүүлэхэд, цаашлаад сонсох, унших, бичих чадварыг сайжруулахад зориулагдсан байна. Номонд орсон бүхий л дасгал ажлуудын түлхүүр үгийг номын ард талд багтаасан болно.

30. Номинзул Т.

Англи хэл өөрөө сурах бичиг 4= Self study English Advanced and academic English.- Улаанбаатар: Соёмбо принтинг, 2019.- 624х.- ISBN 978-9919-21-325-1.

Энэ ном нь англи хэлийг дээд шат болон академик түвшинд "For Advanced and Academic level" өөрөө БИЕ ДААН алхам алхмаар, сэдэв сэдвээр системтэйгээр



үзэж, мөн сурсан мэдсэнээ бататгах олон төрлийн дасгал ажил, тестүүдийг бие даан ажиллан Их дээд сургуульд элсэгчдээс эхлүүлээд IELTS, TOEFL-ийн болон академик түвшинд хүртэл англи хэлний чадвараа сайжруулах боломжийг та бүхэнд олгох болно.


31. Нямсүрэн С.

Англи-Монгол товч толь.- Улаанбаатар:
Шинжлэх ухааны академийн хэвлэх үйлдвэр,
1968.- 253х.

Тус толинд нэг түмэн үг хэллэгийг багтаасаны дотор Улсын их сургуулийн англи хэлний ангийн хичээлийн хөтөлбөрт заасан заавал мэдвэл зохих идэвхтэй үгс, хэллэг мөн орчин үеийн чухал шаардлагатай, нийгэм улс төр, эдийн засаг, техник, шинэлэх ухаанбы нэр томъёо орсон.



32. Оюунцэцэг Ж.



Англи хэлний зүй= English grammar.- Улаанбаатар: 2007.- 415х.- ISBN 99929-8-018-4.

33. Оюунцэцэг Ж., Увш П.

Англи хэл өөрөө сурах бичиг / Хян. Ц.Сумьяа.- Улаанбаатар: Мөнхийн үсэг, 1999.- 280х.- ISBN 99929-8-020-6.

Зах зээлийн харилцаанд шилжиж буй өнөө үеи англи хэлийг сурах хэрэгцээ, шаардлага улам бүр өссөөр байгаа билээ. Энэхүү хэрэгцээтэй уялдуулан англи хэлийг бие дааж үзэх боломж олгох зорилгоор тус номыг бичлээ.



34. Оюунцэцэг Ж.

Англи хэл өөрөө сурах бичиг / Хян. Ц.Сумьяа.- Улаанбаатар.- Мөнхийн үсэг, 2016.- 306х.- ISBN 978-99962-3-763-8.



Уг ном нь нийт 30 хичээлээс бүрдэх ба авиа зүй, хэлзүй, яриа бичгийн дадал, бичгийн хэл зэргийг багтаасан ерөнхий англи хэлээс гадна бизнесийн англи хэлийг түлхүү оруулсан ба хичээл бүрд унших, бичих, сонсох, ярих чадварыг хөгжүүлэх харилцан яриа, текст, дүрмийн товч

тайлбар, сонсголын болон бусад дасгалуудыг оруулсан.

35. Пүрэвжав Э, Туяа Ж.


Таван хэлний зурагт толь.- Улаанбаатар.:
Монсудар, 2010.- 400х. ISBN: 978-99962-0-163-9.

Энэхүү толь бичиг нь монголд хамгийн түгээмэл хэрэглэгддэг 5 хэлний орчин цагийн үгийн сан бүхий зурагт толь юм. Толь бичиг нь дотроо олон сэдэвчилсэн хэсэгт хуваагдаж өдөр тутмын амьдралын, тухайлбал зоогийн газар, биеийн тамир, ажил, гэр, сансар огторгуй, ан амьтан гэх мэт төрөл бүрийн сэдвүүдийг хамран оруулснаараа онцлогтой. Өндөр түвшинд хийгдсэн дизайн болон зураглалууд нь 6000 үгийн санг тодорхой ойлгомжтой байдлаар дүрслэн үзүүлсэн. бөгөөд энэ нь тухайн үгсийг зөвхөн нэрээр нь биш зургаар нь харж тогтооход чухал ач холбогдолтой юм.



36. Сумъяа Ц.

Англи хэлний 1000 сорилго / Хян.
С.Эрдэнэчимэг.- Улаанбаатар: 2005.- 193х.-
ISBN 999-292-144-7.



Энэхүү сорилгыг ажиллаж сурснаар МУИС-ийн гадаад хэл, соёл судлалын сургууль болон мөн их сургуулийн бусад дээд сургууль, факультетэд англи хэлээр элсэлтийн шалгалт өгөх боломжтой. Англи хэлний дунд түвшинд хүсэн хүн энэхүү сорилгыг ажиллаж аливаа, дамжаа сургалтад

шалгалт өгч болохын зэрэгцээ TOFEL-ийн бэлтгэл болгон ашиглаж болно.

37. Сүрэн Б.


Англи- Монгол ярианы дэвтэр= English Mongolian phrase book / Хян. М.Шинэхүү.- Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар, 1968.- 121х.

Англи болон Монгол хэлний өдөр тутмын яриа, шинэ үг, харилцан яриа, өгүүлбэрийг ойлгомжтойгоор орчуулан энэхүү номонд бичсэн.



38. Таван хэлний зурагт толь.- Улаанбаатар: 2010.- 1191х.- ISBN 978-99962-66-03-6.

Орчин үеийн хүний ярьдаг англи, хятад, солонгос, орос болон төрөлх Монгол хэлээ хавсаргасан таван хэлний толь улам бүр даяаршин байгаа өнөө үеийн уншигч таны хэрэгцээ, шаардлагад нийцэх болно. Түүнчлэн энэхүү толь бичигт тухайн зүйлийг тодорхой зургаар харуулах төдийгүй түүнийхээ талаар гүнзгийрүүлэн мэдэхэд тань тус дэм болно.



39. Түмэндэлгэр А.

Англи хэлний нийтлэг алдаа. / Хян. Д.Төмөртогоо.- 232х.- ISBN 99929-71-01-0.



Энэ ном нь Англи хэл сурч байгаа бүх хүнд түгээмэл тохиолддог үндсэн гол алдааг богино хугацаанд засаж, зөв ярьж, бичиж сургөдгөөрөө дэлхийн бүх оронд алдаршиж, англи хэл сурч буй хүн бүрийн ширээний ном болж чаджээ.

40. Түмэндэлгэр А.

Англи хэлний нийтлэг алдаа= Common mistakes in English / Хян. Д.Төмөртогоо.- Улаанбаатар: Арцот хэвлэлийн газар, 2001.- 232х.

Энэ номыг нийтийн хэрэглэдэг зөв бичих аргаас илүү үр дүнтэй шигшмэл аргаар бичсэн нь уг сэдвээр хэвлэгдсэн бусад номоос ялгарах нэг онцлог болсон. Номонд бүх алдаатай үгийг сурагч, оюутнуудыг танихад хялбар болгож онцолсон. Хоёр дахь онцлог нь лавлах, сурах бичгийн алингаар нь ч ашиглах боломжтой учир энэ ном Англи хэл сураглцагч Монгол хүүхэд, залуусын ширээний ном болно гэдэгт итгэж байна.



41. Үнэнбат Д.

Англи хэлний сонсох ном / Хян. С.Эрдэнэчимэг, Л.Дорждэрэм, 2011.- 128х.- ISBN 99929-3-176-0.



“Англи хэлний сонсох ном” нь англи хэлийг эхлэн суралцагч болон багга, дунд сургуулийн сурагчдад англи хэлийг эх хэлээр нь зөв, цэвэр, аялагагүй /акцентгүй/ дуудаж сурахад уг номын утга оршино.


42. Хатанбаатар Х.

Ой тогтоолтын аргаар гадаад үг цээжлэх нь.-
Улаанбаатар: 2018.- 166х.- ISBN 978-99978-2-
513-1.

Энэ ном танд уураг тархиа зөв ойлгон түүний нөөц боломжийг бүрэн дайчилж гадаад үгийг хялбархан цээжлэх дадал олгох болно. Тархины тань унтаж буй хэсэг сэрж, билэг танхай төсөөллүүдийг ургуулан бодож байх зуур та өөрөө ч анзааралгүйгээр хэдэн зуун үгсийг цээжлэх чадвартай болсон байх вий. Монголчууд аа тархиа удирдан гадаад хэл сурч дэлхийн хүн байх эрхээ бүрэн эдэлцгээе.



43. Хүн бүрт зориулсан Англи хэл дүрмийн ном = English for everyone: Анхан шат 1.- Улаанбаатар: Монсудар, 2016.- 184х.- ISBN 978-99973-1-277-8.




Уг ном нь бүх насны хүмүүс хялбар бөгөөд найдвартай аргаар англи хэл эзэмшихэд зориулсан ном билээ. Мэдээж бие даан сурах гэдэг утгаараа бусад номоос нэлээд ялгаатай. Дүрэм, шинэ үг, жишээ бүгдийг

ойлгоход ямар ч хүндрэлгүй болгох үүднээс тайлбарын хажууд зурагт дүрслэлүүд ашигласан байгаа. Сурах бичгийн дагуу ажиллахад багшийн зааваргүй бол ойлгоход бэрх учир бие даан хичээллэхэд хүндрэлтэй байдаг. Харин энэ номд бүхий л шаардлагатай дүрмийг ойлгомжтой байдлаар тайлбарласан ба сурч хичээллэхэд маш энгийн бөгөөд сонирхолтой хэлбэртэй.


44. Хүн бүрт зориулсан Англи хэл Дасгалын ном = English for everyone: Анхан шат 1.- Улаанбаатар: Монсудар, 2016.- 176х.- ISBN 978-99973-1-276-1.

Анхан шатны 1-р хичээл нь Англи хэлээр өөрийгөө танилцуулах, энгийн цагуудыг ашиглан юмс үзэгдлийг дүрслэх зэрэг чадварыг эзэмшихэд чиглэсэн дүрмийн тайлбар, шинэ үг, сонсох материал болон дасгалуудыг агуулсан.



45. Хүн бүрт зориулсан Англи хэл Дүрмийн ном = English for everyone: Анхан шат 2.- Улаанбаатар: Монсудар, 2016.- 184х.- ISBN 978-99973-1-278-5.


Англи хэлийг бие даан хурдан хугацаанд сурахад зориулагдсан уг ном нь дүрмийн тайлбар, бүх талын чадварыг хөгжүүлэх олон төрлийн дасгал, үнэгүй дуут бичлэгтэй. Дүрмийн тодорхой




тайлбарууд нь ямар ч хүнд дүрэм ойлгоход хялбар болгосон. Дуут бичлэгийн жишээнүүд нь сонсоод ойлгох чадварыг дээшлүүлэхээс гадна яриагаа төрөлхийн мэт болгоход тусална.

- 46.** Хүн бүрт зориулсан Англи хэл Дасгалын ном = English for everyone: Анхан шат 2.- Улаанбаатар: Монсудар, 2016.- 176х.- ISBN 978-99973-1-279-2.

Ажиллах дасгалууд нь мэдээж бичих, ярих, унших, сонсох зэрэг үндсэн чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн олон төрлийн хэлбэртэй ба богино дасгалууд нь өөрийн хурдад тааруулан хичээллэхэд тусална.




- 47.** Хүн бүрт зориулсан Англи хэл дүрмийн ном = English for everyone: Дунд шат 3.- Улаанбаатар: Монсудар, 2016.- 288х.- ISBN 978-99973-1-281-5.




Дунд шат нь илүү гүнзгий түвшинд цагуудыг ашиглах, тэдгээрийн онцлог үгсийг өгүүлбэрт зөв байрлуулах, цаг, тоог зөв хэлэх зэргийг хөгжүүлэхэд чиглэсэн, шинэ үг, сонсох материал болон дасгалуудыг агуулсан.

- 48.** Хүн бүрт зориулсан Англи хэл дасгалын ном = English for everyone: Дунд шат 3.- Улаанбаатар: Монсудар, 2016.- 264х.- ISBN 978-99973-1-280-3.

Сурах бичигт үзсэн шинэ мэдлэгийг бататгах зорилгоор дасгалуудбг дэс дараалалтайгаар хуваасан болно. Сурах бичгийн хажуугаар дасгалын номыг анхааралтай үзэх нь сурсан зүйлсээ тогтоож мэдлэгээ хурдан дээшлүүлэхэд чухал юм.




- 49.** Хүн бүрт зориулсан Англи хэл дүрмийн ном = English for everyone: Ахисан шат 4.- Улаанбаатар: Монсудар, 2016.- 288х.- ISBN 978-99973-1-275-4.



Энэ шатанд Англи хэлийг илүү мэргэжлийн орчинд ашиглаж сурахад чиглэсэн технологи, хууль, хурал, зөвлөгөөн зэргийн хэрэглээний үг хэллэг, дүрмийг агуулсан.

50. Хүн бүрт зориулсан Англи хэл дасгалын ном= English for everyone: Ахисан шат 4.- Улаанбаатар: Монсудар, 2016.- 264х.- ISBN 978-99973-1-282-2.


Энэ шатанд Англи хэлийг илүү мэргэжлийн орчинд ашиглаж сурахад чиглэсэн технологи, хууль, хурал, зөвлөгөөн зэргийн хэрэглээний үг хэллэг, тайлбар дасгалуудыг агуулсан.



51. Энхтайван Н.

Танд хэрэгтэй 100 захидал= 100 English letters, 2014.- 204х.- ISBN 978-99973-937-2-2.

Энэ номонд нийт 100 англи жижиг хэмжээний захидал, эссэ өгүүллэгүүд орсон бөгөөд урилга бичих, өргөдөл гаргах, ажилд орох хүсэлт гаргах, ятгах, санал болгох, гомдол гаргах, эмгэнэл илэрхийлэх, баяр хүргэх, уучлалт гуйх, өдрийн тэмдэглэл хөтлөх, энгийн захидал бичих,



интернетийн орчинд ажиллах, и-мэйл бичих, илтгэл тавих, мэдэгдэл хийх, зарлал нийтлэх, хүсэлт тавих, тодорхойлолт бичих зэрэгт бидний өдөр тутмын амьдралд байнга хэрэглэгдэж байдаг түгээмэл үг хэллэгийг аль болох түлхүү оруулсан байна. Ялангуяа англи хэллэг, бичлэгийн хэлбэр, илэрхийлэх

арга барилыг зөв гаргаж захидал, эссэг бичих чадвар олгох юм.

Хүний нэрийн хэлхээс

А		И	
Алтангэрэл Д	2	Итгэл Л	17
Арго Б	3, 4		
		Л	
		Левина И.И	8
Б		Лувсанжав Ч	14
Базаррагчаа М	5	Лхагвасүрэн Б	15
Бат-Ирээдүй Ж	5		
Батсүх Г	6	М	
Баярмөнх Ц	6	Манга Л	17
Болдбаатар Д	7	Мөнгөнтуяа Б	15
Бонк И.А	8, 9	Мөнхтэгш Р	16
Бонк Н.А	8, 9		
		Н	
Г		Нарантуяа Ж	16, 17
Гүн-Үйлс Д	9, 10, 11	Номинзул Т	17, 18
Гэндэндарам Ж	11	Номунзул Б	5
		Нямсүрэн С	19
		О	
Д		Одгэрэл Г	3, 4
Даваа Д	12	Оюунбилэг Г	3, 4
Даваахүү П	12	Оюунцэцэг Ж	19, 20
Дашдондов Ц	13		
Дорждэрэм Л	13, 24	П	
Дорждэрэм Л	13	Пүрэвжав Э	21
Драгункин А.Н	14		
Дулмаа Т	14		
Дэлгэрмаа Х	5		

С		Ү	
Сумъяа Ц	21	Үнэнбат Д	24
Сумъяа Ц	20	Х	
Т		Хатанбаатар Х	25
ТогтохтөрТ	17	Хонгорзул Б	5
Төмөртоого Д	23	Ш	
Туяа Ж	21	Шинэхүү М	14, 22
Туяагэрэл С	7	Шүрхүү Н	17
Түмэндэлгэр А	23	Э	
Тэгшжаргал М	8, 9	Энхтайван Н	29
Тэгшжаргал Т	9	Энэбиш Б	2, 4
У		Эрдэнэчимэг	21, 24
Увш П	20		
Ундармаа Н	17		

ЭМХТГЭСЭН

Фондчин Т.Нямсүрэн

Мэдээллийн ажилтан Б.Оюунзаяа

